

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 2.3 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 1.9 дахин давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.3 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Асгат, Наран, Онгон, Түвшинширээ, Уулбаян, Эрдэнэцагаан, Түмэнцогт сумдын төсвийн орлогын төлөвлөгөө нь 2.0-97.3 хувиар давж биелэсэн байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 1.3 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн хэмжээнээс 68.0 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Эхний улирлын байдлаар 155.3 сая төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт хийгдсний 170.5 сая төгрөг нь боловсролын салбарт, 80.0 сая төгрөг нь төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын салбарт, 48.6 сая төгрөг нь эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт, 21.5 сая төгрөг нь нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээний салбарт, 5.2 сая төгрөг нь ХАА-н салбарт тус тус оржээ.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр **ХААН, Хадгаламж, Хас банк** -наас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 21.9 тэрбум төгрөгт хүрсэн нь 2010 оны жилийн эцсээс 2.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн хадгаламжийн хэмжээ 13.1 тэрбум төгрөг болсон нь 2010 оны жилийн эцсээс 1.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөн банкуудын хугацаа хэтэрсэн зээл 0.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 5.4 хувь болох 46.1 мянган эх мал төллөж, гарсан төлийн 99.0 хувь болох 45.9 мянган төл бойжиж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс доогуур гүйцэтгэлтэй байна.

Оны эхний малын 1.3 хувь болох 25.5 мянган мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 98.7 хувьтай байна.

Нийт хорогдлын 52.6 хувь нь ямаа, 37.9 хувь нь хонь эзлэж байна.

Асгат, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон, Халзан, Баяндэлгэр сумдад оны эхний малын 4.7 - 0.8 хувь болох 23.6 мянган толгой мал хорогдоод байгаа нь нийт хорогдлын 92.6 хувийг эзлэж байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 7.4 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 0.9 тэрбум төгрөгөөр доогуур байна.

Оны үнээр 31.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 3.9 тэрбум төгрөгөөр доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс талх, хиам, нүүрс, дулаан үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.

V. ТЭЭВЭР, ХОЛБОО: Тээвэр: Тээвэр бүхий байгууллагууд 14788.3 мян.тн.км-ийн ачаа эргэлт, 2359.5 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийж гүйцэтгэн 1.8 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Холбоо: Холбоо ашиглалтын орлого 55.4 сая төгрөг байгаагийн дотор 16.4 сая төгрөг нь хүн амаас орсон байна. Телефон цэгийн тоо 1567 болж урьд оны мөн үеэс 50.2 хувиар өссөн байна.

VI. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 3-р сард өмнөх 2010 оны жилийн эцсийнхээс 2.3 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 4.3 хувиар өсч түүн дотор саахар, жимсний чанамал, зөгийн бал, чихэр, шоколаднаас бусад нэр төрлийн үнэ 2.4-15.5 хувиар өссөн байна.

Хувцас, бөс бараа, гутал, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, гэр ахуйн тавилга, бараа, согтууруулах ундаа, тамхий, мансууруулах бодис, тээвэр болон бусад бараа үйлчилгээний үнэ, тариф 0.1-2.1 хувиар өсч, үлдсэн бүх бүлгийн үнэ, тариф тогтвортой байлаа.

VII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 1.1 тэрбум төгрөг болж төлөвлөгөөгөө биелүүлжээ. Сайн дурын даатгуулагчид 19.5 сая төгрөгний шимтгэл оруулсан боловч, төлөвлөгөө нь 24.4 хувиар тасарсан байна. 6009 өндөр настанд 2.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгохоос бүрэн олгосон байна. Нийгмийн халамжийн сангаас 0.2 тэрбум, хүний хөгжил сангаас 3.6 тэрбум, улсын төсвөөс 0.5 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

VIII. ЭРҮҮЛ МЭНД: Эхний 3 сард 313 эх амаржиж, 315 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр байна.

Халдварт өвчнөөр 137 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 4-өөр олон байгаа бөгөөд тэмбүү, заг зэрэг өвчлөлтүүд өссөн байна.

IX. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1016 болж, эхний 3 сард 113-аар нэмэгдсэн байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 81.4 хувь нь 16-34 насны залуучууд байна.

Боловсролын түвшинээр авч үзвэл 23.7 хувь нь дээд, 2.6 хувь нь тусгай дунд, 33.2 хувь нь бүрэн дунд, 7.1 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний 3 сард 490 хүн шинээр бүртгүүлж, 365 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 130 хүн ажиллаж байна.

X. ГЭМТ ХЭРЭГ: Эхний 3 сард 39 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 7-оор доогуур байна. Гэмт хэргийн улмаас 8 хүн нас барж, 11 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 14.1 сая төгрөгийн хохирол учирсны 12.1 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 23 хүн холбогдон сэжиглэгдсэний 30.4 хувь нь согтуугаар, 52.2 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 738 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 253 хүнээр олон байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 40 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

XI.МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ ТӨСӨЛ: Төслийн хүрээнд 13 суманд 4 даатгалын нэгжийн 89 төлөөлөгч ажиллах эрхээ аваад байна.

2011 оны эхний 3 сарын байдлаар малын индексжүүлсэн даатгал хийгдээгүй байна.

XII. ДААТГАЛ: Даатгалын байгууллагуудын хураамжын орлого 11.4 сая төгрөг орж, төлөвлөгөө нь 60.2 хувиар тасарсан байна. 112 хүнд 4.5 сая төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Үүнээс авто тээврийн хэрэгсэлд 2.3 сая, гэнэтийн осолд 1.5 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 0.7 сая, хүүхдийн гэнэтийн осолд 0.04 сая төгрөгийг тус тус олгожээ.

XIII. ТӨСЛҮҮДИЙН ЗЭЭЛ ОЛГОЛТ: ХЭДСан: Аймгийн хэмжээгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 34.4 сая төгрөгийн зээл олгож, 39 хүний ажлын байрыг бий болгосон байна.

ТА-2 төсөл: Тогтвортой амжиргаа II төслийн хүрээнд аймгийн хэмжээгээр 36.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, тохижуулалтанд 19.4 сая, бусад үйл ажиллагаанд 17.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС